

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ДАЛАЙ, УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРЫН ЗОРИЛТЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

/2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар/

Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт	Хэрэгжүүлэх заалт /тоо чанар, хүрэх үр дүн/	Хэрэгжилт /тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин/
<p>2.117. Далайн тээвэр, хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг өргөжүүлж, дотоодын гол мөрөн нууруудад байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалын аюулгүй усан замын тээврийг хөгжүүлнэ.</p>	<p>2.117.1. Далайн тээвэр, хөлөг онгоцны бүртгэлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх</p>	<p>Хууль, тогтоомжийн тухай хуулийн 12.3.2-т заасны дагуу “Монгол Улсын олон улсын гэрээгээр Монгол Улс тухайн асуудлаар дотоодын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулахаар тусгайлан үүрэг хүлээсэн” бол хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу тооцоо, судалгаа хийх шаардлагагүй бөгөөд ОУДБ-аас Монгол Улсад хийсэн аудитын шалгалтын тайлан болон шалгалтын дүнд өгсөн зөвлөмжийг үндэслэн Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг шууд батлуулах боломжтой гэж үзсэн. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 157 дугаар тушаалаар шинэчлэн байгуулагдсан Ажлын хэсэг “Далай ашиглах тухай” хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын төсөл болон хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яамаар батлуулсан. Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт Гадаад харилцааны яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Батлан хамгаалах яам зэрэг төрийн захиргааны төв байгууллага болон Монголын Далайн нийгэмлэг, Монголын Далайчдын холбоо зэрэг ТББ-ын 20 гаруй төлөөлөгч оролцов. Хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад гарсан болон яамдаас ирүүлсэн саналуудыг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр болсон Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн хуулийн төсөлд тусгах асуудлыг шийдвэрлэв.</p> <p>Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Засгийн газрын 2018 оны 201 дүгээр тогтоолын хавсралтад заасан Олон улсын гэрээ, конвенцуудын шаардлагуудыг тусган оруулсан болно. Далайн захиргаанаас Ажлын хэсэгт орсон гишүүд “Монгол Улсын Хөлөг онгоцны бүртгэлд хөлөг онгоц бүртгэх журам”-ын төслийг шинэчлэн боловсруулан ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т 2019 оны 10 дугаар сарын 08-ны өдөр 1/213 тоот албан бичгээр хүргүүлсэн. Заалтууд хуулийн төсөлд тусгагдсан. Хуулийн төсөл батлагдсаны дараа энэхүү журмыг Монгол Улсын Засгийн газраар батлуулах юм.</p> <p>Хуулийн төслийг Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн ба хуралдааны үеэр гаргасан саналыг тусгасан хуулийн төслийг Зам, тээврийн хөгжлийн сайд 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдөр УИХ-д өргөн барьсан. Улсын Их Хурлын 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаас Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн шийдвэр гарсан. Уг хуралдаанаар Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан</p>

	<p>Зөрчлийн тухай хуулийн төсөлд орох нэмэлт өөрчлөлтийг эргэн харж нягтлахыг даалгасны дагуу 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр хуулийн төсөл боловсруулах Дэд ажлын хэсэг хуралдаж, уг асуудлыг хэлэлцэв. Зөрчлийн тухай хуулинд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг шинэчлэн дахин боловсруулав.</p> <p>УИХ-ын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан “УИХ-ын намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалт”-ын 88 дугаарт Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэхээр тусгасан байна. УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсэг уг хуулийн төсөл дээр ажиллаж байгаа болно.</p> <p>Далай ашиглах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэх Эдийн засгийн байнгын хорооны ажлын хэсгийн хуралдаан 2021 оны 01 дүгээр сарын 06-нд хуралдаж хуулийн дэд ажлын хэсгийг байгуулсан. Уг дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Далайн захиргаанаас 2 ажилтан орж ажиллаж байна. Дэд ажлын хэсгийн хуралдааныг 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж хуулийн төсөлд санал өгч ажиллав.</p> <p>“Монгол Улсын нэгдэн орсон далайн салбарын гэрээ, конвенцыг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-г Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 201 дүгээр тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна. Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд уг тогтоолын хавсралтад заасан Олон улсын гэрээ, конвенцуудын шаардлагуудыг тусгаад байна.</p> <p>“Далбааны эзэн улсын хяналт, үзлэг шалгалт явуулах журам”-ын төслийг “Далай ашиглах тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан зүйл заалтууд болон ОУХБ-ын “Далайн хөдөлмөрийн тухай” 2006 оны конвенцтой уялдуулан боловсруулж, журмын төсөлд нөлөөллийн шинжилгээ хийж, журмын төслийг танилцуулгын хамт 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 1/112 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. “Хөлөг онгоцны байршил тогтоох, алсын зайнаас хянах системийг ашиглах, үйл ажиллагааг зохицуулах журам”-ын төслийг боловсруулан Далайн захиргааны даргын 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 22 дугаар тушаалаар батлуулан мөрдөж байна. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 201 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын нэгдэн орсон далайн салбарын гэрээ, конвенцыг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд “Олон улсын далайн байгууллагын конвенц, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам” боловсруулж, батлуулахаар заасан бөгөөд тогтоолын хэрэгжилтийг хангаж, далайн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор “ОУДБ-ын конвенц, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын төслийг боловсруулан 2020 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 1/220 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. Дээрх ажлууд Далайн захиргааны 2020 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан болно.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 201 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “Олон улсын далайн байгууллагын аудитын шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх залруулах арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх 2020-2021 оны нарийвчилсан ажлын төлөвлөгөөг Далайн захиргааны даргын 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 25 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>ОУДБ-ын “Далайчныг сургах стандарт, гэрчилгээ олгох болон ээлжийн ажиллагааны тухай” 1978 оны конвенцын 2010 оны Манилагийн нэмэлт, өөрчлөлтийг УИХ-аар соёрхон батлуулах ажлын хүрээнд конвенцын орчуулгыг ГХЯ-</p>
--	---

		<p>аар хянан баталгаажуулсан. Конвенцод нэгдэн орох тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад хэргийн сайд болон Зам, тээврийн хөгжлийн сайд нараар батлуулсан. Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаас уг хуулийн төслийг УИХ-д өргөн барихаар шийдвэрлэсэн бөгөөд УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлэхэд хуралдаанд оролцсон гишүүдийн 72,2 хувь нь хуулийн төслийг дэмжсэн.</p> <p>УИХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн нэгдсэн чуулганаар "Далайчныг сургах стандарт, гэрчилгээ олгох болон ээлжийн ажиллагааны тухай" 1978 оны конвенцын 2010 оны нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орох тухай хуулийн төслийг" хэлэлцэн баталсан. Хуулийн төслийг УИХ-аар соёрхон батлуулахад мэдээлэл, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, дэмжлэг үзүүлэн ажиллав.</p> <p>Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Далайн хөдөлмөрийн тухай" 2006 оны конвенцын 2014 оны нэмэлт, өөрчлөлтөд Монгол Улс нэгдэж орох тухай хуулийн төслийг 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2019 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хурлаар уг хуулийн төслийг хэлэлцүүлэхэд холбогдох мэдээ, мэдээллээр хангаж ажиллав. УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хурлаар "Далайн хөдөлмөрийн тухай" конвенцын нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг амжилттай хэлэлцүүлж УИХ-ын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн чуулганаар хэлэлцүүлэн батлуулав. Хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхэд Далайн захиргаанаас мэргэжлийн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэн ажиллав.</p> <p>ОУХБ-ын "Далайн хөдөлмөрийн тухай" 2006 оны конвенцод оруулсан нэмэлт, өөрчлөлтийг "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд хэвлэн нийтлүүлэх ажлыг зохион байгуулж, 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн №02 дугаарт нийтлүүлсэн. Тус конвенцыг Монгол Улс соёрхон баталсан тухай Батламж жуух бичгийг Олон улсын хөдөлмөрийн байгууллагад бүртгүүлснээр гишүүн улсад үйлчилж эхлэх бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас батламж бичгийг ГХЯ-нд хүргүүлсэн. Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу ГХЯ-наас Батламж бичгийг тухайн байгууллагад хүргүүлэн, мэдэгдэх үүрэгтэй. Хуулийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхэд Далайн захиргаанаас мэргэжлийн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлэн ажиллав.</p>
	<p>2.117.2. Далбааны эзэн улсын үүрэг хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгож, Монголын хөлөг онгоцны бүртгэлийн</p>	<p>Далбааны эзэн улсын үүрэг, хариуцлагын тогтолцоог үе шаттайгаар боловсронгуй болгох ажлыг Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 201 дүгээр тогтоолоор баталсан "ОУДБ-ын гэрээ, конвенцыг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний дагуу гүйцэтгэж байна.</p> <p>Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийг Улаанбаатар боомтод төвлөрүүлэх арга хэмжээний хүрээнд хөлөг онгоцны бүртгэлийн, дуудлагын болон радио холбооны дугааруудыг Далайн захиргаа 2017 оноос эхлэн Улаанбаатар боомтоос олгож байгаа бөгөөд өссөн дүнгээр 795 хөлөг онгоцыг Улаанбаатар боомтоос бүртгээд байна. 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд 28 хөлөг онгоцыг шинээр бүртгэсэн.</p> <p>Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагаанд зуучлагч агентын сонгон шалгаруулалт зарласан бөгөөд БНСУ-ын "Космос марин бюро" компани, БНСВУ-ын "Роял марин" компаниудыг тус тус шалгаруулж, эдгээр компанитай</p>

	<p>чанарыг сайжруулах, өргөжүүлэх</p>	<p>гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор бүртгэлийн зуучлагч /агент/-ийн сонгон шалгаруулалтыг явуулж, шинээр Турк Улсын "Раяах Маритайм Сурвей Сервисес Форейн Трейд" компанитай агентын гэрээ байгуулан ажиллаж эхлээд байна. Мөн Кипр Улсын "Ностра Шиппинг Сервис" компанитай зуучлалын гэрээний нөхцөлийг тохиролцож тодорхой тооны хөлөг онгоц бүртгүүлсний дараа гэрээ байгуулах нөхцөлтэйгээр хамтран ажиллаж байна.</p> <p>Европын холбооны бүс нутагт хөлөг онгоцны бүртгэлийн зах зээлд нэвтрэх зорилгоор Нидерланд улсын Ангиллын нийгэмлэг болох Датч Ллойд компанийг хөлөг онгоцонд техникийн үзлэг, оношилгоо хийх Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар ажиллуулах гэрээг 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр байгуулаад байна. Мөн тус компани нь хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын үүргийг гүйцэтгэхийн сацуу хөлөг онгоцны бүртгэлийн зуучлагч агентын үүргийг давхар гүйцэтгэх боломжтой гэдэг санал тавьсны дагуу агентын гэрээг тухайн өдөр байгуулаад байна.</p> <p>Сингапур улсын "Скай проспекити" компанитай хөлөг онгоцны бүртгэлийн агентын гэрээ байгуулах талаар санал солилцож байна. Мөн Вьетнам улсын "Пионер логистик" компанийг агентын гэрээгээр ажиллуулах талаар судалж байна.</p> <p>Хөлөг онгоцонд техникийн үзлэг шалгалт, оношилгоо хийх Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагатай хамтран ажиллах гэрээний төслийг шинэчлэн боловсруулав. Сингапур Улсын "Сингкласс интернэйшнл" компани, БНХАУ-ын "Чайна класификэйшн" компани, Шанхай хотын "Asia shipping certification services", БНТУ-ын Истанбул хотын "Aegean register of shipping" болон БНСУ-ын "Космос марин бюро" компанитай тус тус шинэчилсэн загварын дагуу гэрээ байгуулаад байна. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдэх хөлөг онгоцнуудад техникийн үзлэг шалгалт, оношилгоо хийх үүрэг бүхий Хүлээн зөвшөөрөгдсөн 18 байгууллагатай хамтран ажиллаж байна. Европын бүс нутгийн хөлөг онгоцны бүртгэлийн зах зээлд гарахын тулд Кипр улсын "Дромон Бюро Шиппинг" компанитай хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын гэрээг 2020 оны 05 дугаар сарын 22-ны өдөр байгуулав. Хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагаанд ЗТХЯ болон ГХЯ-ны хамтарсан ажлын хэсгээс аудитын шалгалтыг 2020 оны 12 дугаар сард явуулсан бөгөөд уг шалгалтын дүгнэлтэд үндэслэн Сингапур Улсын "Сингкласс интернэйшнл" компанийн Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагаар ажиллах гэрээг цуцалж одоогоор Далайн захиргаа нь нийт Хүлээн зөвшөөрөгдсөн 17 байгууллагатай хамтран ажиллаж байна.</p> <p>Олон Улсын холбогдох гэрээ, конвенцын дагуу хүлээсэн Далбааны эзэн улсын үүргийг хэрэгжүүлэх зорилгоор 2019 онд Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй 7 хөлөг онгоцонд үзлэг шалгалт хийлээ. Хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын үйл ажиллагаанд далбааны эзэн улсаас хяналт тавих журмын төсөл, танилцуулга, төсөлд хийсэн нөлөөллийн шинжилгээний хамт 2019 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 1/164 тоот албан бичгээр, Далайн осол, зөрчлийг шинжлэн шалгах журмын төсөл, нөлөөллийн шинжилгээ, танилцуулгыг 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 1/251 тоот ЗТХЯ-нд тус тус хүргүүлээд байна.</p> <p>Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцны аюулгүй байдлыг хангах зорилгоор Олон улсын хиймэл дагуулын байгууллагаас хүлээн зөвшөөрөгдсөн ИБУИНВУ-ын "Fulcrum Maritime Systems" компанитай хөлөг онгоцны байршлыг тогтоох, алсын зайнаас хянах үйлчилгээ үзүүлэх тухай гэрээг 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр байгуулан ажиллаж байна. Энэхүү гэрээний дагуу Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй 30 хөлөг</p>
--	---------------------------------------	--

		<p>онгоцонд уг системийн дагуу хяналт тавин улирал бүрд үйл ажиллагааны тайлан авч ажиллаж байна. Мөн Олон улсын хөдөлгөөнт хиймэл дагуулын байгууллагаас жил бүр тухайн байгууллагад үйл ажиллагааны аудитын шалгалт хийдэг бөгөөд энэ жилийн аудит 2020 оны 9 дүгээр сард хийгдэж, аудитын тайланг 11 дүгээр сарын 26-нд хүлээн аваад байна. Тайлангаар тус компанийн үйл ажиллагааг "хангалттай" гэж дүгнэсэн байна.</p>
	<p>2.117.3. Байгаль орчинд ээлтэй усан замын тээврийг хөгжүүлэхэд анхаарч төрийн байгууллагууд, хувийн хэвшил, иргэд хоорондын уялдаа холбоог сайжруулах эрх зүйн орчныг сайжруулах</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан энэхүү зорилтын хүрээнд "Усан замын тээврийн тухай" хуулийг 2018 онд батлахаар төлөвлөсөн боловч Монгол Улсын Засгийн газраас уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийг "Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийн хамт 2017 онд УИХ-д өргөн мэдүүлж, батлуулсан. "Усан замын тээврийн тухай" хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг аймаг, орон нутагтаа зохион байгуулан ажиллах талаар Далайн захиргаанаас гол мөрөн, нуур бүхий аймгуудын Засаг дарга нарт холбогдох албан тоотыг хүргүүлсэн.</p> <p>Түүнчлэн хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд усан замын тээврийн салбарын захиргааны хэм хэмжээний акт болон стандартыг шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах ажлыг хийж байна.</p> <p>"Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох" журмыг шинэчлэн боловсруулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 119 дүгээр тушаалаар батлуулан ажиллаж байна. Энэхүү журмыг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулснаас гадна хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>"Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх, сургалтын хөтөлбөр батлах" журмын төсөл, төслийн танилцуулга, нөлөөллийн шинжилгээний хамт боловсруулж, 2018 оны 07 дугаар сарын 03-ны 1/168 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн. "Усан замын тээврийн тухай" хуулинд уг журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтай хамтран батлахаар заасан. Үүний дагуу дээрх журмын төслийг боловсруулах хамтарсан ажлын хэсэг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 252 дугаар тушаалаар байгуулагдсан.</p> <p>"Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам, сургалтын хөтөлбөр" боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Далайн захиргааны ЗУХ-ийн дарга, Усан замын тээврийн бүртгэл, хяналтын албаны ахлах мэргэжилтэн, усан замын тээврийн хяналт хариуцсан мэргэжилтнүүд орж ажилласан. Далайн захиргааны зүгээс ажлын хэсгийн хуралд тогтмол оролцож, бусад гишүүдтэй мэдээлэл солилцох, журмын төсөлд тусгах саналыг боловсруулах зэрэг ажлыг хийсэн.</p> <p>Ажлын хэсгийн хуралд (2019.03.15) ОХУ-ын сургалтын хөтөлбөр, стандартыг судалж, орчуулсан материалаа танилцуулсан. Ажлын хэсгийн гишүүдээс гаргасан саналыг нэгтгэн журмын төсөлд тусгах ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх журам, Сургалтын жишиг хөтөлбөр Зам, тээврийн хөгжлийн сайд болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн</p>

	<p>269/A/271 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан бөгөөд Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн байна.</p> <p>Дээрх журмын хэрэгжилтийг хангах зорилгоор “Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолооч бэлтгэх сургалтын стандарт, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах ажил”-ын /багц-2/ гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах ДЗ/201903007 дугаартай тендерийг зохион байгуулав. Уг ажлын гүйцэтгэгчээр “Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээ, мэдээлэл, арга зүйн төв” шалгарч, 2020 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Ажил гүйцэтгэх гэрээг байгуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллав. Усан замын тээврийн хэрэгслийн жолоочийн ажил, мэргэжлийн дүн шинжилгээ (DACUM) хийх хэлэлцүүлгийг 2020 оны 06 дугаар сарын 06-ны өдөр, ажил мэргэжлийн лавлах, сургалтын стандартын төсөлд санал авах хэлэлцүүлгийг Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд 2020 оны 06 дугаар сарын 22-26-ны өдрүүдэд гүйцэтгэгчтэй хамтран тус тус зохион байгуулсан. Уг хэлэлцүүлгүүдэд усан замын тээврийн хэрэгслийн жолооч нар /завьчид/ болон Далайн захиргааны холбогдох мэргэжилтнүүд оролцсон.</p> <p>Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолоочийн сургалтын хөтөлбөр, стандартыг боловсруулах ажлыг эхлүүлсэн бөгөөд мэргэжлийн чиглэл индексийг батлуулах саналыг боловсруулж, 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 1/64 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн хурлаар усан замын тээврийн хэрэгслийн жолооч, мэргэшсэн жолоочийн ажил, мэргэжлийн лавлахыг хэлэлцүүлэн батлуулаад байна.</p> <p>ЗТХЯ-наас боловсруулсан “Усан замын тээврийн хэрэгсэл, объектын техник ашиглалтын дүрэм”-ийн төслийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 277 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>“Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох журам”-ын төслийг боловсруулж, журмын төслийн танилцуулга, нөлөөллийн шинжилгээг хийж, ЗТХЯ-нд 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдөр 1/286 тоот албан бичгээр хүргүүлсэн. Уг журам нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 78 дугаар тушаалаар батлагдаж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн. Энэхүү журмыг Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан “Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа” сэдэвт семинарын үеэр оролцогчдод танилцуулсан.</p> <p>Усан замын тээврийн хэрэгсэлд хийх техникийн хяналтын үзлэгийн төлбөрийн жишгийг тогтоох тухай Монгол Улсын Засгийн газрын тогтоолын төсөлд тусгах санал, танилцуулгыг боловсруулж, Зам, тээврийн хөгжлийн яаманд 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 1/66 тоот албан бичгээр хүргүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд бусад улсын /ОХУ болон Их британи, АНУ/ үзлэгийн үнэ, тарифын талаар судалгааг хийж, танилцуулгад тусгасан. Засгийн газрын “Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төлбөрийн жишиг батлах тухай” 2019 оны 248 дугаар тогтоолын талаарх мэдээллийг Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан “Усан замын тээврийн аюулгүй ажиллагаа” сэдэвт семинарын үеэр оролцогчдод танилцуулсан.</p>
--	--

		<p>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 248 дугаар тогтоолоор батлагдсан Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийн төлбөрийн жишиг үнийн дагуу 2019, 2020 оны техникийн хяналтын үзлэгийг явуулав.</p> <p>Усан замын тээврийн хэрэгсэлд тавигдах техникийн ерөнхий шаардлагын төслийг боловсруулах ажлын хүрээнд ОХУ-ын усан замын тээврийн хэрэгсэлд тавигдах техникийн ерөнхий шаардлагатай холбоотой эрх зүйн баримт бичгийг судалсан. ЗТХЯ-наас “Усан замын тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлага”-ын төслийг боловсруулж ирүүлсэн бөгөөд уг төсөлд тусгах саналыг Далайн захиргаанаас 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 1/104 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>“Усан замын тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлага”-ын төслийг усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгчдийн дунд хэлэлцүүлэх ажлыг “Монголын завьчдын нэгдсэн холбоо” ТББ-тай хамтран зохион байгуулсан бөгөөд олон нийтээс санал авах зорилгоор байгууллагын цахим хуудаст байршуулсан.</p> <p>Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/179 тушаалаар Усан замын тээврийн хэрэгсэлд тавигдах шаардлага батлагдаж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдээд байна.</p> <p>Олон улсын стандарт, хэмжил зүйн байгууллагаас батлан гаргасан ISO 6185-1 хийлдэг завины стандартын орчуулгын төслийг боловсруулж, Онцгой байдлын ерөнхий газар болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас тус тус санал авах ажлыг зохион байгуулав. Стандартын орчуулгын төслийг Далайн захиргаанаас 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 1/158 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>/Бүрэн хэрэгжсэн./</p>
	<p>2.117.4. Хөвсгөл нуурт усан замын төв зогсоол, дэд бүтцийг хөгжүүлэх аюулгүй байгаль орчинд ээлтэй усан замын тээврийн үйл ажиллагааг сайжруулах</p>	<p>Хөвсгөл нуурт усан замын төв зогсоол, дэд бүтцийг хөгжүүлж, аюулгүй, байгаль орчинд ээлтэй усан замын тээврийн үйл ажиллагааг сайжруулах зорилтын хүрээнд Хөвсгөл аймагт усан замын төв зогсоол барих хөрөнгийн эх үүсвэрийг төр, хувийн хэвшлийн түншлэлээс бий болгох, гадаадын зээл тусламжийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.</p> <p>ЗТХЯ-ны Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтэстэй хамтран боловсруулсан ажлын даалгаврын төсөлд Барилга, хот байгуулалтын яам болон БОАЖЯ-наас санал авах ажлыг ЗТХЯ-тай хамтран зохион байгуулсан.</p> <p>Дээрх бүтээн байгуулалтын ажлын урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулах үнийн саналыг аж ахуйн нэгжүүдээс авч ЗТХЯ-ны Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтэст цахим шуудангаар хүргүүлсэн.</p> <p>“Усан замын төв буудал”-ын зураг төсөл, урьдчилсан ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг Монгол Улсад хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх тухай саналаа ЗТХЯ-аар дамжуулан холбогдох байгууллагуудад уламжилсан болно.</p>

	<p>Түүнчлэн ОХУ-аас авах хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлэх саналтай байгаа талаар холбогдох албан бичгийг ЗТХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Монгол Улсын Засгийн газраас улс, орны эдийн засгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан концессын гэрээгээр аливаа ажил, үйлчилгээ гүйцэтгэх асуудлыг 2018 он хүртэл түр зогсоосон.</p> <p>Усан замын төв буудлын зураг, төслийг боловсруулах, барих, өмчлөх, ашиглах концесс эзэмшигчийг сонгох уралдаант шалгаруулалт явуулахыг хүссэн албан бичгийг холбогдох баримт материалын хамт ЗТХЯ-наас 2017 оны 12 дугаар сард Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн. Үндэсний хөгжлийн газраас дээрх концесс эзэмшигчийг сонгох уралдаант шалгаруулалтын баримт бичиг боловсруулах, зарлах, төслийн санал үнэлэх, концессын гэрээний хэлэлцээр хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж байгаа талаар манай байгууллагад албан бичгээр мэдэгдсэн. Уг албан бичгийн дагуу Ажлын хэсэгт орж ажиллах албан тушаалтны нэрийг холбогдох мэдээллийн хамт 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдөр Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн боловч ажлын хэсэг Үндэсний хөгжлийн газар дээр өнөөг хүртэл байгуулагдаагүй байна.</p> <p>Эдийн засаг, төсвийн хүндрэлтэй байдлыг харгалзан улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр эргэн төлөгдөх нөхцөлтэй концессын гэрээг байгуулахгүй байх талаар Монгол Улсын Засгийн газар 2016 онд 37 дугаар тогтоол гаргасан. Уг тогтоол хэрэгжиж эхэлснээр Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний энэхүү заалтад тусгагдсан “Усан замын төв буудал”-ын барилгыг концессын гэрээгээр барих хөрөнгийн асуудал нь одоог хүртэл хэрхэн шийдвэрлэгдэх нь тодорхойгүй байгаагаас хэрэгжээгүй байна.</p> <p>Иймд Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан “Усан замын төв буудал” барих асуудлын хэрэгжих хугацааг сунгах, өөрчлөлт оруулах тухай саналаа ЗТХЯ-нд 2018 оны 11 сарын 07-ны өдрийн 1/263 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Хөвсгөл нуурын эрэгт усан замын төв буудал барих 1 га газрыг үйлчилгээний зориулалтаар ЗТХЯ-нд эзэмшүүлэх асуудлыг Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2017 оны А/16 дугаар захирамжаар шийдвэрлэсэн. Газар эзэмшүүлэх тухай уг захирамжийг өөрчлүүлэн газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг Далайн захиргааны нэр дээр гаргуулах талаар Зам, тээврийн хөгжлийн сайдаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу орон нутгийн захиргааны байгууллагаар зохих шийдвэр гаргуулах хүсэлтийг 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр хүргүүлж, тухайн газрын кадастрын зургийг мэргэжлийн байгууллагаар хийлгээд байна. Энэхүү газар нь Хөвсгөл аймгийн 2 сумын нутаг дэвсгэрт хамаарагдаж байгаа асуудлаар орон нутгийн удирдлагуудтай тогтмол харилцаж, шийдвэрлүүлэх талаар анхаарч ажиллаж байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 332 дугаар тогтоолоор баталсан “Хөвсгөл нуур орчмын “эко аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх (2019-2023 он) төлөвлөгөө”-нд усан замын төв зогсоолын байгууламжийн зураг төслийг боловсруулах төсвийн асуудлыг тусгуулсан. Уг төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах үүднээс Усан замын төв зогсоолын байгууламжийн зураг төслийг боловсруулах ажлыг ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-ын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулах талаар саналаа хүргүүлсэн.</p>
--	---

	<p>ЗТХЯ-ны захиалгаар Үндэсний хөгжлийн газраас “Хөвсгөл нуурын эрэгт усан замын төв буудал байгуулах” төслийн уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахаар төлөвлөөд байгаа бөгөөд уг уралдаант шалгаруулалтыг зарлахаас өмнө тухайн төслийн нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ, урьдчилсан зардал, үр ашгийн тооцоо болон хөрөнгө оруулалтаа хэрхэн нөхөх талаарх тооцоо судалгаа (урьдчилсан ТЭЗҮ)-г Бодлогын шийдэл” ТББ-аар хийлгэж, ЗТХЯ-ны холбогдох мэргэжилтэнд цахим шуудангаар хүргүүлсэн.</p> <p>Үндэсний хөгжлийн газраас зарлахаар төлөвлөж буй Хөвсгөл нуурын эрэгт “Усан замын төв буудал байгуулах төсөл”-ийн концессын уралдаант шалгаруулалтын Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Далайн захиргааны Усан замын тээврийн бүртгэл, хяналтын албаны ахлах мэргэжилтэн Т.Олонбаярыг ажиллуулахаар нэрийг нь дэвшүүлж 2020 оны 06 дугаар сарын 30-ны өдөр 1/140 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>БНСУ-ын KOICA олон улсын байгууллагаас Монгол Улсын зам, тээврийн салбарт хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөлд “Хөвсгөл нуурын эрэгт усан замын төв буудал байгуулах” ажлыг хэрэгжүүлэх зардал төсвийн асуудлыг тусгуулах саналаа Далайн захиргаанаас 2020 оны 07 дугаар сарын 16-ны өдөр 1/147 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Шинээр байгуулагдсан Монгол Улсын Засгийн газрын 100 хоногийн хугацаанд Зам, тээврийн салбарт хийгдсэн ажлуудыг Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулахаар 2020 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулагдсан арга хэмжээний үеэр Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд барих “Усан замын төв буудал” төслийн барилга, байгууламжийн загвар макетыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, төсвийн хэрэгжилтийн явцын талаар танилцуулсан.</p> <p>Хөвсгөл нуурын эрэгт “Усан замын төв буудал” барих 1 га газрыг үйлчилгээний зориулалтаар Зам, тээврийн хөгжлийн яаманд олгосон газар эзэмших эрхийн гэрчилгээг Далайн захиргааны нэр дээр гаргуулах тухай Зам, тээврийн хөгжлийн яамнаас 2019 онд /08/259 тоот/ Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Засаг даргад хүргүүлсэн албан бичгийн шийдвэрлэлт шийдвэрлэгдэхгүй удаашралтай байсан. Учир нь “Усан замын төв буудал”-ын зориулалтын газар нь Хөвсгөл аймгийн Ханх болон Алаг-Эрдэнэ сумдын нутаг дэвсгэрт тус тус хамаарагдаж байгаагаас газар эзэмших зөвшөөрлийг шилжүүлэн олгох асуудлыг Хатгал тосгоны Захирагч бие даан шийдвэрлэх боломжгүй байгаа тухайгаа өмнө нь манай байгууллагад мэдэгдсэн.</p> <p>Иймээс “Усан замын төв буудал” барих зориулалттай 1га газраас дээрх сумдын нутаг дэвсгэрт хамаарагдаж байгаа хэмжээгээр нь газрын эзэмших эрхийн гэрчилгээг Далайн захиргааны нэр дээр тус тус гаргуулахаар дээрх орон нутгийн удирдлагуудтай хэд хэдэн удаа уулзаж, мөн хүсэлтээ 2021 оны 01 дүгээр сарын 27-ноос эхлэн гаргасан. Түүнчлэн газрын кадастрын зургийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн.</p>
--	--

		Одоогоор газар эзэмших зөвшөөрлийг шилжүүлэн олгох асуудлыг Хөвсгөл аймгийн Ханх сум болон Хатгал тосгоны захиргаанаас тус тус шийдвэрлэсэн тухайгаа манайд мэдэгдээд байна.
--	--	---

ДАЛАЙН ЗАХИРГАА